



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/08

Хатан суудал

Г Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн Г  
тоо бүртгэлийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Гэрэлмаа (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Амаржаргал (5-р багийн Засаг дарга)

Д.Жаргалмаа (Газрын даамал)

Н.Мөнхгэрэл (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

П.Норовсамбуу (Нярав)

Нарийн бичгийн дарга: Х.Бямбажаргал (Цаг уурч)

3. Агаарын бохирдлын суурин эх нэгдсэн тооллогыг хугацаанд нь явуулж аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Гэрэлмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  О.МӨНХБАТ